



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/138

Арвайхээр

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт оруулж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны VIII хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацааг сунгасантай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасугай.

2. Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/55 дугаар захирамжийн 2 дахь заалтын согтууруулах ундаа худалдах болон үйлчлэхтэй холбогдох заалтыг өөрчилж, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдах цагийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд 08:00-20:00 байхаар хязгаарлалт тогтоож, баар, караоке, цэнгээний газруудын үйл ажиллагааг дээрх хугацаагаар түр зогсоосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/55 дугаар захирамжийн 2 дахь заалтын “Хүнсний дэлгүүртэй холбогдох хэсэг”, 6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/96 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

4. Захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100299